



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
КОМПАНИУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335  
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,  
Цахим шуудан: info@nccd.gov.mn,  
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.06.05 № 3-3/834.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Үнийн санал авах тухай

Тус төв нь Глобал сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүжилтээр Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS) болон Мобайл аппликейшний (TUB APP)- хөгжүүлэлт, сайжруулалт, хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байна.

Иймд TUB APP-ийн 2026–2027 оны урсгал зардлыг хариуцах, системийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, мөн цахим уулзалт, сургалт зохион байгуулахад шаардлагатай Zoom эрх зэрэг урсгал зардлыг хариуцан гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах гэж байна.

Сонирхсон байгууллагууд дээрх ажлуудыг гүйцэтгэх үнийн саналаа холбогдох баримт бичгийн хамт ирүүлнэ үү.

Үнийн саналд дараах мэдээллийг тусгана уу:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Нийлүүлэх хугацаа /2026.06.30 дууссан байх/
3. Үнийн саналын албан бичиг
4. Хөгжүүлэгчийн хийсэн ажлуудыг тусгаж өгнө. Сүрьеэгийн цахим систем, болон апп хөгжүүлж байсан доод тал нь 2 жилийн туршлагатай.

Үнийн санал ирүүлэх хугацаа нь 2026 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 16 цаг 30 минут хүртэл байна. Үнийн саналыг [tender@nccd.gov.mn](mailto:tender@nccd.gov.mn) хаягаар и-мэйлээр ирүүлнэ үү.


Дэлгэрэнгүй мэдээллийг 72224244 дугаараас лавлана уу.

ЗАХИРАЛ



С.ЭНХБОЛД

Халдварт өвчин судлалын үндэсний  
төвийн ерөнхий захирлын 2026 оны  
3-3/234 дугаартай албан бичгийн хавсралт



### ХИЙГДЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Зардлын төрөл	Хугацаа	Тайлбар
1	SSL сертификат	2 жил	Системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах
2	Apple Developer Program	2 жил	iOS платформ дээр TUB APP-ийг ашиглах, шинэчлэх эрх
3	Google Workspace	24 сар	Албан ёсны цахим шуудан болон системийн үйлчилгээ
4	Google Play Developer Account	Нэг удаа	Android платформ дээр аппликейшн байршуулах эрх
5	PDF App лиценз	1	PDF тайлан, баримт боловсруулах үйлчилгээ
6	Zoom эрх	1 жил	Цахим сургалт, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах